

Үндэсний аюулгүй байдал
“Эмэгтэйчүүдийн нүдээр” IV чуулган
2009 оны 3-р сарын 6

Цагаачлал ба хүн худалдах гэмт хэрэг

*С.Дондов, Хуульч; Хүний эрх хөгжил төвийн
Хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрийн Зохицуулагч*

Монгол улс ардчилсан нийгэмд 1990 онд шилжснээр манай орны иргэд гадаадад чөлөөтэй зорчих эрхээ эдлэх болсон. Энэ цаг үеэс эхлэн монголчууд төрөл бүрийн зорилгоор гадаадын олон улс оронд ажиллаж, амьдарч, сурч, аялж байна.

Энэ байдал нь иргэдийн гадаадад чөлөөтэй зорчих, цагаачлах эрхээ хэрэгжүүлж байгаа маш чухал алхам боловч нөгөө талаас үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн нэг хэлбэр болох хүн худалдах гэмт хэрэгт охид эмэгтэйчүүд өртөх явдал сүүлийн жилүүдэд нэмэгдэж Монгол улсын иргэдийн хүний аюулгүй байдлыг алдагдуулж, улмаар үндэсний аюулгүй байдалд аюул учруулж буй хүчин зүйл болоод байна.

1994 оноос эхлэн гадаадад хөдөлмөр эрхлэх, суралцах, жижиг дунд бизнес хийх, аялах, жуулчлах явдал нэмэгдэж, албан бус тоогоор 130 мянга орчим иргэн гадаадын 30 гаруй оронд сурч, ажиллаж амьдарч байгаа тухай мэдээ байна. Гадаад Хэргийн Яамны консулын газраас гаргасан мэдээгээр гадаадад 87000 иргэн хууль ёсоор байгаа бөгөөд тэдгэрийн 29000 нь гэрээгээр ажиллагсад, 10000 нь оюутан, 18000 нь цагаач, 21000 нь Казакстанд давхар харьяалалтай иргэд байна. Түүнчлэн ойролцоогоор 33000 иргэн гадаадад хууль бусаар оршиж байна.

Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 9.5-д заахдаа: “Гадаадад хувийн хэргээр түр хугацаагаар зорчиж яваа Монгол улсын иргэн өөрөө хүсвэл дипломат төлөөлөгчийн болон консулын газарт бүртгэл хийлгэж болно” гэсэн нь гадаадад байгаа иргэдийн тоог бодит байдлаар гаргахад бэрхшээл учруулдаг байж болох юм.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны 2008-2012 оны мөрийн хөтөлбөрийн 5.1.8-д “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрхийг тууштай хамгаалж монгол иргэдэд туслах сан байгуулна” гэж заасан нь гадаад оронд амьдарч буй иргэдийн эрх ашгийг хамгаалах шинэ боломжийг нээж байгаа боловч тухайн орныхоо Элчин сайдын яам, консулын газар бүртгүүлээгүй, хууль ёсны эрх ашиг нь зөрчигдөн хохирч буй монголчууд энд хамрагдах боломжгүй байгааг үгүйсгэх газаргүй юм.

Дээрхи 130 гаруй мянган монголчуудын ажиллаж амьдарч буй орнуудтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ болон гэмт этгээдийг шилжүүлэн өгөх гэрээ байгуулаагүй орнууд нилээд байна. Ялангуяа монголчууд олноор амьдардаг орнуудтай дээрхи эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ болон гэмт

хэрэгтнийг шилжүүлэн өгөх тухай гэрээнүүдийг байгуулаагүй байгаа нь Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн дээрх заалт дээр нэрмээс болж байна гэж үзэхээр байна.

БНСУ-д дор хаяад 35000 иргэн ажиллаж амьдарч байгаа бөгөөд энэ улсад эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ болон гэмт этгээдийг шилжүүлэн өгөх гэрээ байгуулсан. Харин АНУ-д 22000 иргэн ажиллаж амьдардаг гэсэн багцаа тоо байгаа бөгөөд энэ улсад дээрхи гэрээнүүдийн аль аль нь байхгүй байна. БНЧУ-д 13000 иргэн байгаа гэдэг бөгөөд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан харин гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх гэрээ байхгүй байна. Их Британид 9000 иргэн амьдардаг ч дээр дурдсан 2 гэрээг байгуулаагүй байна.

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ болон гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх гэрээ байгуулаагүй, хэдэн хүн гадаад оронд амьдарч байгаагаа тодорхой гаргах боломжгүй байгаа өнөө үед Монгол улс цагаач ажилчид, тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай НҮБ-ын олон улсын конвенц"-ид нэгдэн орох зайлшгүй хэрэгцээ байгааг анхааран үзэх цаг болжээ. Энэ конвенцид нэгдэн орсноор цагаач ажилчдад нийтлэг тохиолддог хууль бус үйл ажиллагаануудаас иргэдээ хамгаалж чадах юм.

Тухайлбал, олноор нь албадан гаргахаас хамгаалах, ямар нэгэн байдлаар ялгаварлахгүй байх, тухайн хүний иргэний бичиг баримтыг хураахгүй байх, ар гэртээ мөнгө гуйвуулах, нас барсан тохиолдолд шарилыг нь эх оронд нь буцаахад нь дэмжлэг үзүүлдэг гэх мэт олон давуу талуудтай билээ.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 4-р бүлэг буюу Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал гэсэн хэсэгт Хүний эрх эрх чөлөөг бататган хамгаалсан олон этгээдийн гэрээ, конвенцид нэгдэж орохын зэрэгцээ, өөрийн иргэдийн ашиг сонирхлыг хамгаалсан хоёр талын гэрээ, хэлэлцээр байгуулах тухай дурдсан байгаа нь ихээхэн ач холбогдолтой билээ.

Монголчууд олноор зорчих болсон мөн тухайн оронд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох тохиолдол ч нилээд байгаа Макао, Малайз, Гонконг, Сингапур, Турк зэрэг орнуудад иргэдийн ашиг сонирхлыг хамгаалсан хоёр талын гэрээ байгуулах шаардлагатай байгааг анхааран үзэх хэрэгтэй байна.

Хуурамч зар сурталчилгаа, хуурамч амлалтанд итгэн харийн нутагт очиж хүн худалдах гэмт хэргийн хохирогч болсон олон хүмүүс төрийн хамгаалалтыг авч чадахгүй, хүний газар зовж шаналан өдөр хоногийг өнгөрөөж байна.

Гэтэл дээрхи үзэл баримтлалын 4-р бүлгийн 3 дахь хэсэгт “гадаадад аялж, явж байгаа Монгол улсын иргэдэд тэдний эрхээ мэдэж хамгаалах талаар мэдээлэл өгдөг механизм буй болгохын дээр гадаадад суугаа Монгол улсын дипломат төлөөлөгчийн газрын иргэдийнхээ эрхийг хамгаалах үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх хүний эрх эрх чөлөөг хамгаалах засгийн газрын бус тогтолцооны үйл ажиллагааг дэмжих тухай заажээ.

Мөн Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 9.1-д МУ-ын иргэн гадаадад байхдаа төрийнхөө ивээлд байж, зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хуулийн дагуу хамгаалуулах эрхтэй гэж заасан байдаг. Гэвч бодит амьдрал дээр дээрх заалтуудын хэрэгжилт тун хангалтгүй байгаад сэтгэл зовниж байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 5-р бүлэг буюу “Эдийн засгийн аюулгүй байдал” гэдэгт ажилгүйчүүд, түүний дотор хөдөлмөрийн насны хөдөлмөрлөх чадваргүй хүн амын тоо хэт ихсэх нь эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болох дотоод хүчин зүйл мөн гэж үзжээ.

Гэвч иргэн бүрийг баталгаатай ажлын байраар хангаж гэр бүлийнхээ хэрэгцээг хангалттай байлгаснаар гэр бүл бодитой оршин тогтнох боломжийг тусгаж өгөөгүйгээс олон иргэд гадаадад өндөр цалинтай ажил хийх олон улсын жишигт нийцэж амьдрахаар гадны орныг зорьж хуурамч амлалтанд итгэн хүн худалдах гэмт хэргийн золиос болж байна.

Хүн худалдах гэмт хэрэг нь нэг талаас үндэстэн дамнасан зохион байгуулалттайгаар нууцаар үйлдэгддэг учраас хохирогчдыг хамгаалах, эх оронд нь буцаах, эргэн нийгэмшихэд нь туслахад ихээхэн бэрхшээл учирдаг гэмт хэргүүдийн нэг юм.

Монгол улсын хувьд хүн худалдах гэмт хэргийн асуудлаар бусад улс оронтой хамтран ажиллах санаачилга муу байгаагаас хүн худалдах гэмт хэрэг үйлдэгчдийг бүрэн илрүүлж чадахгүй, хохирогчдыг авран хамгаалах ажил удаашралтай байна.

Жил ирэх тусам хүн худалдах гэмт хэрэгт өртөж буй хохирогчдын тоо нэмэгдэж гэмт хэрэгтнүүдэд тодорхой хэмжээгээр ял шийтгэл оногдуулж байгаа боловч хохирогчдын сэтгэл санаа, эд материалын хохирлыг бүрэн хэмжээгээр барагдуулах асуудал орхигдсон хэвээр байгаа билээ.

Энэ нь нэг талаас хохирогчдыг хамгаалах хууль эрх зүйн орчин хангалтгүй, үүнд сэтгэл санааны хохирлоо үнэлэн төлүүлэх боломжгүй байдал, нөгөө талаас тухайн хэргийг мөрдөн шалгаж буй хуулийн байгууллагуудын үйл ажиллагаа хэт удаашралтай байгаагаас хохирогчдыг залхаах, мэдүүлгээсээ буцах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгосоор байна.

Мөрдөн байцаалтын болон прокурорын хяналтын явцад гэмт хэрэгтнүүдийн эд хөрөнгийн байдлыг бүрэн тогтоож, битүүмжлэн хамгаалдаггүй зэрэг хохирогчдын хохиролыг барагдуулах тал дээр анхааралгүй ханддагаас хохирогчид эд материалын хохирлоо ч төлүүлж авч чадахгүй байх тохиолдол түгээмэл байна.

Өнгөрсөн хугацаанд Хятадад 40 гаруй, Малайзид 8, Өмнөд Солонгост 6, Туркид 6, Израйлд 2 гэх мэтээр монгол эмэгтэйчүүд худалдагдан хохирсон байсныг манай Элчин сайдын яам, Олон улсын шилжин суурьшилтын байгууллага, Хүйсийн тэгш эрхийн төвтэй хамтран авч ирсэн байна.

Дээрхи хохирогчдыг нөхөн сэргээх, хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, эргэж хэвийн амьдралд нь оруулахад туслах зэрэг хамгийн ярвигтай ажлуудыг хийх талаар төрөөс ямар нэгэн алхам хийгээгүй байна.

Харин Солонгос болон Малайзаас ирсэн хохирогчдыг эргэн нийгэмшихэд болон тэдэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ажлыг Хүйсийн тэгш эрхийн төв, хууль зүйн зөвлөгөө өгөх болон мөрдөн байцаалтын үед болон шүүхээр хэргийг нь шийдвэрлүүлэх явцад өмгөөлөгчөөр хангах ажлыг Хүний эрх хөгжил төв зэрэг төрийн бус байгууллагууд Олон улсын шилжин суурьшилтын болон Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хийж гүйцэтгэж байна.

Гэтэл одоо Масао, Гонконгд манай улсын 17-38 насны 400 орчим байнгын биеэ үнэлэгчид байгаа бөгөөд эдгээр хүмүүсийн хэд нь бэлгийн мөлжлөгт өртөж, хэд нь сайн дураараа биеэ үнэлж байгааг нарийвчлан тогтоосон зүйл одоогоор алга байна. Мөн эдгээр хүмүүсийг эх оронд авч ирэх ажлын байраар хангах, гэр бүл үр хүүхдүүдтэйгээ хамт амьдрах боломжоор хангах асуудалд төрөөс тусгайлан анхаарах шаардлагатай байгаа билээ.

Хувь хүний зараар гэр бүл болохоор зуучлуулах асуудал монгол улсад түгээмэл байна. Аль нэгэн гадаадын орны зуучлах товчоотой албан ёсоор гэрээ байгуулаагүй, хувь хүний итгэл дээр үндэслэн таамаг төдийгээр явж харийн бэр болон мөлжлөгийн хөдөлмөрт өртөх тохиолдол ч байна.

Зуучлах алба гэдэг нь зөвхөн таньдаг хүнийхээ хүрээнд зуучлах үйл ажиллагаа явуулдаг ба гадаадын иргэний зургийг авчран харуулах, мөн монгол охидын зургийг авч интернэтэд тавих, эсвэл зуучлуулахыг хүссэн гадаадын иргэнд товч танилцуулан зургийг илгээдэг тохиолдлууд элбэг байна.

Хэрвээ эмэгтэйн зураг таалагдаж танилцахыг хүсвэл гадаадын иргэн манай улсад ирж сонгосон бүсгүйтэйгээ уулздаг. Зарим тохиолдолд монгол эмэгтэйд урилга өөрийн оронд аваачин амьдрах явдал түгээмэл байна.

Тухайн эмэгтэй гадаадад гарсны дараа ямар нэгэн аюулд учрахгүй гэсэн баталгаа байхгүй. Зуучилж байгаа хүмүүс манай эмэгтэйчүүд гадаадын иргэнтэй суугаад олон жил сайхан амьдарч байгаа гэж хэн нь тодорхойгүй, янз бүрийн зураг үзүүлж сайн сайхан зүйл ярьж итгүүлэхийг оролддог байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн нэг хэлбэр болсон зуучлалын журмаар гадаад иргэдтэй гэр бүл болж буй хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох талаар төрөөс өнөөдрийг хүртэл дорвитой арга хэмжээ авахгүй байна.

Сүүлийн үед Казакстан, Турк зэрэг орнууд руу ажилд зуучилна гэсэн хуурамч амлалтанд итгэн хохирсон хүмүүс ТББ-гад хандах боллоо. Эдгээр хүмүүст амьдрах байр, хоол үнэгүй, ажилд оруулсан байгууллага нь хариуцна, авах цалингийн хувьд доод тал нь 500 доллар сайн ажиллавал цаашид нэмэгддэг гэсэн хуурамч мэдээллийг өгч зуучилсныхаа мөнгийг аваад явуулдаг байна.

Очсон хойно ямар нэгэн үнэгүй байр хоол байхгүй, амласан ажилд нь орж чадаагүй байтал 1 сарын хугацаатай виз нь дуусч тухайн орны цагдаа нараас нуугдан хүний газар стандартын бус байранд олноороо амьдарч мөнгө төгрөггүйгээс болж эмэгтэйчүүд нь бэлгийн мөлжлөгт өртөх, эрэгтэйчүүд нь хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, архинд орох зэргээр өөрийгөө жолоодох чадваргүй болж эх орондоо ирж чадахгүй байх тохиолдлууд элбэг байна.

Иймд:

- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд хүний аюулгүй байдлыг хангах зорилгоор хүнийг бэлгийн, болон мөлжлөгийн хөдөлмөрт өртөхгүй байх бодит боломжоор хангах тухай заалт нэмж оруулах нь зүйтэй байна.
- Гэр бүлийн хуулийн 9-р зүйлд гэрлэхэд харшлах шалтгаан гэдэгт зуучлалын журмаар хэн нэгнийгээ, тодорхой хугацаанд таньж амжаагүй буюу танихгүй гадаад улсын иргэнтэй хууран мэхлэгдэж гэрлэх асуудлыг хориглосон заалт нэмж оруулах
- Гадаадын иргэнтэй гэрлүүлнэ, виз гаргана, ажилд зуучилна гэх мэт хууль бус заруудад хяналт тавих, хүн худалдах гэмт хэргийн төрөл бүрийн хэлбэрт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор гадаад орныг зорьж буй хүмүүст зориулсан гарын авлага бэлтгэн тарааж байх, сургалт зохион байгуулах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран зохион байгуулж байх
- Хууль бусаар зуучлах алба ажиллуулж иргэдийг хууран мэхэлж төөрөгдөлд оруулж буй хүмүүст хариуцлага тооцох механизмыг бий болгох
- Гэр бүл болох зорилгоор зар сурталчилгаа гарган тухайн хүний эдийн засгийн эмзэг байдлыг нь ашиглан гэрлэж буй байдлыг хууль бус гэрлэлтэд тооцох
- Хүн худалдах гэмт хэрэгт өртөх нөхцлийг бий болгосон байгууллага, зар түгээгчид болон хувь хүмүүс, энэ гэмт хэргийг үйлдэгчдээс торгууль нөхөн төлбөрийн хэлбэрээр гаргуулсан эрсдлийн сан бий болгох
- Гадаад орны иргэнтэй гэр бүл болж, улмаар бэлгийн болон биеийн хүчний мөлжлөгт өртөж эрүүл мэнд, сэтгэл санаа, эд материалын хохирол амссан иргэнд, хариуцагч нь гадаад орны иргэн гэдэг үндэслэлээр хэргийг түдгэлзүүлсэн, хэрэгсэхгүй болгосон хэргийн тухайд хохирлыг урьдчилан гаргуулж төлүүлдэг болох, нөхөн төлбөр олгох асуудлыг хуулиар зохицуулах
- ХХГХ-ийн төрөл бүрийн хэлбэрт өртөж хохирсон эмэгтэйчүүдийг эх оронд нь авч ирэх, тэдний аюулгүй байдлыг хангах талаас нь анхааралтай хандаж монгол эмэгтэйчүүд сүүлийн жилүүдэд олноор гэрлэх болсон Солонгос, Хятад зэрэг орнуудын энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах

- Жил бүрийн төсөвт ХХГХ-ийн хохирогчдын нөхөн сэргээх ажилд зориулж зардал тусгаж байх
- Хууль хяналтын байгууллагуудын ажилтнууд эрх зүйн харилцан туслалцах гэрээг сайтар ашиглахад нь дэмжлэг мэдлэг олгох
- Гэрээний ашиглалтыг сайжруулах, хүн худалдах гэмт хэргийн хохирогчид байж болох магадлал бүхий орнуудтай ЭЗХТГ гэрээ байгуулах нь зөв гэж үзэж байна.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.